



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 05

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5.2.1 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 482,166.6 /Дөрвөн зуун наян хоёр мянга нэг зуун жаран зургаан төгрөг жаран мөнгө/-ний анхны өртөгтэй 477,074.07 /Дөрвөн зуун далан долоон мянга далан дөрвөн төгрөг долоон мөнгө/-ний хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтын дагуу акталж устгахыг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгө актлах ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР